

Оршуулгын соёлд холбогдох онтологийн зарим асуудал

Очирпүрэвийн Мөнхцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ ахисан түвшний
хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс

Мөнхцэрэнгийн Золзаяа  

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
 zolzaya.m@mnuac.edu.mn

Хураангуй: Оршуулгын соёл нь нас барагчид хүндэтгэл үзүүлэх ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэл, сэтгэл зүй, ёс зүй, соёлын гэсэн оюун санааны хүчин зүйлсийн нөлөөн дор хэрэгждэг. Нас барагчийг ёс заншил, уламжлалын дагуу хүндэтгэх, түүний дурсгалыг мөнхжүүлэх нь оршуулгын соёлын гол зарчим юм. Соёлын онтологи, монголчуудын оршуулгын зан үйлд холбогдох судалгааны бүтээлүүдэд тулгуурлан антропологийн онтологи хандлагын үүднээс оршуулгын соёлд холбогдох үндэслэлүүдийг харьцуулан авч үзэх, онтологийн үзэл баримтлалуудыг тоймлон тайлан тайлбарлах аргыг голлон баримтлав. Цаашид оршуулгын соёлын уламжлалыг соёлын философи, экологи, антропологи, шашин судлал зэрэг нийгэм хүмүүнлэгийн ухааны салбар дундын судалгаагаар шинжлэх шаардлагатай байна.

Түлхүүр үгс: сүнс, нас нөхцөгч, нүүдэлчдийн оршуулга, газар орон, онтологийн шилжилт, хойд төрөл

Ontological some Issues Pertaining to Funeral Culture

Munkhtsetseg Ochirpurev 

Research and Advanced studies, program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

Zolzaya Munkhtseren  

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
 zolzaya.m@mnuac.edu.mn

Abstract: Funeral culture is shaped by spiritual influences, including worldview, religious beliefs, psychology, ethics, and culture, which govern the respect afforded to the deceased. The fundamental tenets of funeral culture involve honouring the deceased

in accordance with customs and traditions, as well as preserving their memory. This paper will analyse the pertinent foundations of funeral culture through the lens of anthropological ontology. This article, based on research works on cultural ontology and Mongolian funeral rituals, focuses on comparing the grounds related to funeral culture from the perspective of anthropological ontology, interpreted and summarize ontological concepts. In the future, it is necessary to analyze the traditions of funeral culture through interdisciplinary research in social and human sciences such as cultural philosophy, ecology, anthropology, and religious studies.

Keywords: *spirit, deceased, nomadic burial, place, ontological transition, rebirth*

Оршил

Соёлын эртний хэлбэрүүдийн нэг бол оршуулгын соёл бөгөөд хойд нас, сүнс гэсэн шүтлэгт үндэслэн нас барагчдыг хүндэтгэх уламжлалыг хамруулсан ойлголт. Оршуулгын соёл нь хүний нийгмийн түүхэн дэх хамгийн анхдагч бөгөөд тогтвортой үзэгдлүүдийн нэг болж уламжлагдсаар иржээ. Оршуулгын зан үйл бол соёлын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тухайн ард түмэн, овог угсааны шүтлэг бишрэл, соёлоос хамаарч янз бүрийн дарааллаар гүйцэтгэдэг онцлогтой юм.

Манайд оршуулгын зан үйл, оршуулгын ёслол гэдэг ойлголтыг түгээмэл хэрэглэж байсан, сүүлийн үед оршуулгын соёл гэдэг ойлголт олон нийтийн ярианы хэлэнд ч хэрэглэгдэх болсон. Судлаачид оршуулгын зан үйлийг нийгмийн харилцааны нэг хэлбэр хүний оршихуйн утга учрыг хүндэтгэх хүчин зүйл болох талаас нь авч үзсэн байдаг. Оршуулгыг зан үйлийн талаас Х.Пэрлээ (1956), Д.Эрдэнэбаатар (2001), Г.Батнасан (2005), Б.Отгонбаатар (2009), зан үйлийн хийгээд төрөөс нас нөхцөгчдийг оршуулах үйл ажиллагааг зохицуулж ирсэн уламжлал Г.Идэрмаа (2023) нар тодруулан эрдэм шинжилгээний өгүүлэл, нэгэн сэдэвт бүтээлийн түвшинд судалжээ. Харин оршуулгын соёлын хүрээнд (Хурцбилэг 2005; Дулам 2025) нийгмийн байр суурь, насны ялгаанаас хамаарч оршуулах хэлбэр, оршуулгын зан үйлийн асуудлыг авч үзсэн байна (Дулам 2025, 614-634).

Оршуулгын соёлд хүн болж төрөөд үхэх үед хүндэтгэл үзүүлэх бэлгэ тэмдгүүд илэрч буй. Оршуулгын соёлын мөн чанар, учир шалтгаан, нийтлэг зүй тогтлыг ахуй ёсны үүднээс эргэцүүлж, түүний онтологи үндэслэлийг тодруулан тайлбарлах нь чухал юм. Ер нь соёлын оршихуй нь байгаль хийгээд оюун санааны ертөнцөд байдаг. М.Шелерийнхээр “соёл бол хүний ухамсарт тусаж, ямар нэг утгаар илэрдэг, хүний туршлагаар дамжиж буй утга санааны ертөнц. Соёл нь сублимаци, өөрөөр хэлбэл, тэмүүллийн энергийг эрчимт байдлын ямар нэгэн зэрэглэл бүхий өөрийн зорилгуудад өөрчлөн хувиргах явдал юм. Тиймээс ч түүхийн явцад байгаль руу буцах үйлд чиглэсэн хандлага илэрдэг нь хөгшрөл болоод амьдралын уруудлын шинж” (Отгонбаяр 2012, 58) ажээ. Эндээс соёл хэрхэн оршдог, соёлын үзэгдэл ба бодит байдлын хамаарал юу вэ? зэрэг соёлын онтологи асуулт урган гарч буй юм. XX зууны эхэн үеэс соёлын онтологи философийн бие даасан чиглэл болон төлөвшихөд үнэлэмжийн онол, бэлгэдлийн онол, философийн хүн судлалын хандлагууд нөлөөлжээ. Иймээс судлаачид соёлын онтологийн анхдагч эх сурвалж

нь “домог” хэмээн үзэж, байгальтай зохицож амьдрах, түүнийг субъект байдлаар хүндэтгэх гэсэн эко ёс суртахууны үүд хаалга, гүүр нь болдогтой холбон (Соёлмаа 2024, 25) тайлбарлажээ.

Судалгааны арга зүй

Оршуулга нь онтологийн хувьд талийгаачийн бие махбод нь амьд биш, сүнс “байж оршин буй” хэлбэр буюу байх байхгүйн заагийг илэрхийлдэг. Оршуулгын соёлын асуудлыг дараах арга зүйгээр авч үзэх боломжтой юм. Тухайлбал, соёлын бэлгэдэл, хэлний далд утгыг тайлан тайлбарлах замаар мөн чанарыг нь таньж мэдэх герменевтик арга нь соёлын онтологид уламжлал, хэл, түүхэн нөхцөл байдлыг ойлгоход чухал үүрэгтэй. Соёл өөр хоорондоо нягт холбоотой тогтолцоо, бүтэцтэй тул соёлын оршихуйг бүрдүүлж буй дотоод зүй тогтол, тогтвортой бүтэц, хэв шинж, харилцан хамаарлыг структурализмын арга зүй илрүүлдэг. Соёлын оршихуй бол утга дамжуулагч тэмдгийн систем (sign system) гэж үзэн соёлын оршихуйг тайлбарлах семиотикийн арга зүйн хандлага бий. Соёлыг байнгын хөдөлгөөн, зөрчил, хөгжил дунд оршдог амьд үйл явц хэмээн тэдгээрийн харилцан үйлчлэлийг диалектик арга зүйгээр судлах боломжтой. Энэ судалгааны хүрээнд холбогдох онолын судалгааны бүтээлүүдийг шинжлэн онтологийн үзэл баримтлалуудыг тоймлон тайлбарлах аргыг голлон баримтлав.

Оршуулгын соёлын судалгааны эх хэрэглэгдэхүүний хувьд талийгаачийн хүйс, нас, байр суурь, угсаа гарал, амьдарч байсан газар орноос хамаарч оршуулах ёсны дараалал, хэлбэр, зан үйл, цээр, оршуулгын дараах зан үйлийн ялгаатай байдлыг илтгэх археологийн дурсгал, домог, аман зохиол, түүхийн сурвалж, баримтууд зэрэг болно. Түүнчлэн оршуулгын зан үйлүүд нь ихэнхдээ домог, шашны судар, хууч яриагаар дамжиж итгэл үнэмшил болсон байдгийг анхаарах хэрэгтэй.

Домог зүйн судалгаанд үлэмж их хувь нэмэр оруулсан М.Елиаде оршуулах зан үйлийг оршихуйн нэг хэлбэрээс нөгөө рүү шилжих үйл явц (ontological transition) гэж үзсэн нь энэхүү асуудлыг судлахад арга зүйн гол үзэл баримтлал болж байна. Тэрээр “Үхэл нь энэ ертөнц дэх бузар оршихуйг төгсгөж, дээд ариун (sacred) оршихуй руу нэвтрэх үүд. Нөгөө талаас ариун бузар орон зайг тусгаарлаж буй босго нь бузар ба шашин хоорондын зайг илтгэнэ. Босго нь хоёр ертөнцийг заагласан хил хязгаар байхын зэрэгцээ бузраас ариун ертөнц рүү нэвтрэх боломжтой парадоксаль газар юм. Эдгээр ертөнц хоорондоо харилцдаг (Mircea Eliade 1956, 25)” хэмээжээ. Энэхүү “оршихуйн босго” нь маш чухал ойлголт бөгөөд манай монголчууд гэрийн үүдний босготой холбогдох зан үйлүүдийг баримталж ирсэн нь сонирхол татаж буй юм.

Судалгааны үр дүн

Хүн төрөлхтөнд сүнсний мөнхийн оршихуй, дээд ертөнц, нөгөө ертөнцөд сүнс үргэлжлүүлэн орших тухай ойлголт нь эртнээс бий болсон нь оршуулгын соёл, зан үйлийн янз бүрийн хэлбэр бүрэлдэхэд нөлөөлсөн байна. Үхэх гэдэг үгийг цээрлэхээс эхлээд оршуулгын өмнөх, оршуулах, оршуулгын дараах гэсэн зан үйлийн дараалал бүхий соёлын бие даасан үзэгдэл бүрэлджээ.

Юуны өмнө хүний оршихуйн тухай онтологийн үзэл баримтлалуудад түгээмэл хэрэглэдэг зарим категори оршуулгын соёлын хүрээнд багтана. Жишээлбэл, сүнс, орон зай, байршил, цаг хугацааны эргэлт, үхэл зэрэг юм.

Хүн хэмээх амьтны сүнс үхэшгүй мөнхийн тухай үзэл санааны эх сурвалж нь сүнс бурханлаг бөгөөд биет бус, эвдрэхгүй, устахгүй, төгсгөлгүй гэдэгт итгэх явдал. Энэ нь бие сүнс хоёрын нэгдлийг илэрхийлж байдаг. Үхэл ба үхэшгүй мөнхийн тухай философийн үзэл нь оюун санааны янз бүрийн практик, тухайлбал үхлийн дараах амьдралыг хангах зориулалттай оршуулгын ёслолын зан үйлүүдийг нөхцөлдүүлдэг (ШУА-ийн ФХ 2023, 1256). Мөн бие ба сүнсний хоёрдмол чанарын асуудал нь сэтгэгчдийн янз бүрийн байр суурь илэрхийлдэг гол сэдвийн нэг болсоор ирсэн юм. Үхэл бол төгсгөл биш, харин ертөнц анх үүсэж байсан тэрхүү ариун эхлэл рүү буцах боломж бүхий мөнхийн эргэлт хэмээн тайлбарласан ч бий.

Эртний грекийн философич Пифагор “Сэтгэл бол үхэшгүй мөнх, тиймээс сүнс дахин төрдөг. Бие бол сэтгэлийн бунхан бөгөөд түүний үзлээр, бие булшлагдахад сүнс чөлөөтэй болно” гэж үзсэн. Энэ баримтлалыг Платон үргэлжлүүлж, бие үхэхэд сэтгэл чөлөөлөгдөж, жинхэнэ амьдралд орно. Иймээс үхэл л сэтгэлийг цэвэр оюун ухаантай золгуулж, шинэ амьдралтай учруулна хэмээсэн бөгөөд тэд сэтгэлийг мөнх гэж үзсэн. Нөгөө ертөнцөд сэтгэл нь шударга, шударга бус, ужиг самуу, хэр тааруу, буян нүгэл хийсэн шалгуураар орж шийтгүүлнэ эсвэл шагнуулна гэж Платон тайлбарлажээ (Цэрэнханд 2018, 92). Энэ үүднээс талийгаачийн сүнс нь биеэс холдсон ч үлдсэн хүмүүсийн үйлдлийг сэтгэлдээ мэдэрч байдаг гэдэг төсөөлөл зайлшгүй юм. Платон сүнс, бие хоёрын харилцааны тухай асуудлыг “Федон” хэмээх зохиолдоо “...бие бол сэтгэлийн орон байр. Сүнс ба биеийн зохист харьцаанд оюун ухаан нөлөөлдөг” гэж үзсэн. Аристотелийн үед сүнс (soul)-ээс илүү сэтгэлийн талаар (psyche) түлхүү ярих болсон байна. Психик бол сэтгэл буюу сэрэл, хүртэхүй, ой санамж, мэдрэхүй, сэтгэхүй, хүсэл зориг зэргийг тусган авсан дээд мэдрэлийн үйл ажиллагааг тэмдэглэдэг ойлголт. Философи сэтгэлгээний түүхэнд “spirit” нь сүнс, субстанц, материаллаг зүйлийн нөгөө тал, сэтгэл зэрэг утгаар хэрэглэгдэж байсан. Теологи, шашны философид сэтгэлийг гол болгон оюун санааны чөлөөлөгдөл, гэгээрэл, оюун санааны чадамж, оюун санааг удирдан чиглүүлэгчийн тухай авч үзсэн байдаг.

Сэтгэл ба сүнсний тухай асуудал нь дорно дахины сэтгэлгээний чухал асуудал юм. Буддын шашинд хүн үхэхийн цагт биеийн дөрвөн махбодын чадамж доройтож, илч алгуур хураагдаад, эрхтний мэдлүүд хаагдаж, эцэст нь ганцхан сэтгэлийн мэдэл орших ба сэтгэлийн мэдэл ч бүдүүнээс эхлэн нарийн хүртэл дараалан хаагдаж, эцэст нь нарийн үхлийн сэтгэлд тулна. Энэ нарийн түвшинд хий сэтгэл хоёр нэг мөн чанартай (Гантөмөр, Дондог 2023, 26). Ийнхүү янз бүрийн шашин, философид сүнсний тухай тайлбар нь архетип, хамтын ухамсаргүй гэх мэт аналитик сэтгэл зүйн онтологи, эпистемологийн өвөрмөц үндэс болдог байна (Цэрэнханд 2018, 99).

Соёлын онтологийн үүднээс оршуулгын соёл нь “байх” (being) ба “байхгүй” (non-being) хоорондын харилцаанд илэрнэ. Үхлийн тухай ойлголтод “байхгүй” нь илүү мэдрэгдэнэ. Үхэл амьдралын төгсгөл үү, эсвэл нөгөө ертөнц рүү хийх шилжилт үү? Энэ асуултад хэрхэн хариулах амьдралын тухай үзэл төлөвшихөд нөлөөлнө. Оршуулгын зан үйл нь хүний оршихуйн хязгаарлагдмал байдал, утга учиртай амьдрахыг сануулдаг бөгөөд “үхэл”-ийг хэрхэн ойлгож буйтай салшгүй холбоотой учир үхлийг соёл бүр өөр өөрсдийнхөөрөө тайлбарладаг бөгөөд шинжлэх ухаан, философид янз бүрийн үзэл, хандлага илэрдэг. Нөгөө талаар XX зууны философид

дэлхий ертөнц, байгаль биш, харин хүн төрөлхтний асуудлыг хөндөх болсноор уламжлалт онтологи байр суурь өөрчлөгдөж, “онтологийн эргэлт” гэх ойлголт бий болсон юм.

Онтологийн эргэлтийн тухай ярьдаг сэтгэгчид “соёл” гэсэн ойлголт нь тодорхой метафизик байдлыг өөртөө агуулдаг гэж үздэг. Онтологийн эргэлт нь соёл, танин мэдэхүй, байгалийн ялгаанд арга зүйн хувьд нээлттэй, суурь шинэчлэлийн хандлагыг баримтлахыг санал болгодог (Heywood, Paolo 2023). Энэхүү эргэлт нь хүний мөн чанарыг илүү нарийвчлан шинжлэхийг сануулсан юм. Мартин Хайдеггерийнхаар амьдрал ямагт үхэл өөд тэмүүлж байдаг, хүн энэ байдлаа ухаарч чадвал өөрийн амьдралын төгсгөлт чанар, мөн үүрэг хариуцлага, эрх чөлөө, мөн чанараа ухаарах боломжоо олдог. Ингэснээр хүн үхлээс өрсөн амьдралаа утга төгөлдөр болгож чадах ажээ (Оюунгэрэл 2006, 186). Өөрөөр хэлбэл, үхэл бол эрх чөлөөнд хүргэн чөлөөлөгдөх арга зам гэжээ.

Эмиль Дюркхеймийн үзлээр үхэл бол нийгмийн бүтцэд учирч буй “цохилт”. Жишээ нь, “Хүннүгийн үеийн булшинд, гэхдээ ихэвчлэн эмэгтэй хүний оршуулгаас хагалсан толины хэлтэрхийнүүд олддог байна. Энэ нь эртний хүмүүс хоорондын хөдөлмөрийн хуваарь, тэр дундаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс харьцангуй мэдрэмтгий, орчноо, өөрсдийгөө мэдрэх илүү чадвартай сэлтийг харуулж байгаа юм” (Ариунболд, Цогтсайхан 1997, 58) гэжээ. Эндээс үзвэл, оршуулгын зан үйл нь “цохилт” мэдэрсэн үлдсэн хүмүүсийг нэгтгэж, хамтын итгэл үнэмшлийг нь бататгадаг, нийгмийн гишүүд хоорондын холбоог бэхжүүлж, хамтын сэтгэл зүйгээрээ дамжуулан нийгмийн тогтвортой байдлыг хадгалахад чухал үүрэгтэй. Дахин төрөхөд итгэх нь тодорхой нийгмийн бүлэг, овог угсааны сэтгэл зүйн тайтгарал, заслын нэг хэлбэр бөгөөд социаль хүчин зүйлсийн нэг болно.

Үхсэн бие махбод бол соёлын утга агуулсан объект учир хэрхэн хадгалах, устгах (чандарлах, ил тавих, оршуулах) нь хүнийг байгаль, ертөнцтэй холбоотой гэж үзэж буйн илрэл. Үүнтэй холбогдуулахуйд, эртний үед нас барагсдыг булшлан оршуулах ёс гарсан нь овгийн тэргүүн дээдсээ хүндлэх, мөнхжүүлэх ёс суртахууны сэтгэлгээний илэрхийлэл байж, энэ нь эх дэлхийгээ шүтэн дээдлэх ёстой ч холбогдон, эх дэлхийн газар шороонд оршуулах нь хүндлэл, мөнхжүүлэлтийн ёс байсан (Дашжамц 1997, 137) гэж судлаачид үзжээ. Өөрөөр хэлбэл, газар эхийг шүтэн дээдлэх зан үйл нь оршуулгын орон зайн тухай ойлголтын салшгүй хэсэг юм.

Орон зай ба цаг хугацааны ойлголт: М.Элиаде “шилжилтийн зан үйл” (rites of passage) гэдэг ойлголтоор оршуулах зан үйлийг хүний амьдралын “хамгийн чухал босго” гэж үзсэн. Талийгаач нь “тусгаарлагдах” буюу хуучин ертөнцөөсөө тасрах, “лиминал” буюу хоёр ертөнцийн дунд зааг дээрх үе, нэгдэх буюу өвөг дээдсийн эсвэл бурхдын ертөнцөд шинэ байр суурьтай орох гэсэн үе шатыг туулна. Цаг хугацааны үргэлжлэлийн хувьд өмнөх үе, амьдрал төгсөх үе, оршуулгын өмнөх үе, оршуулгын үе, оршуулгын дараах үе, хойд насны үе гэсэн дарааллууд бий (Mircea Eliade 1956, 184). Ингэхээр оршуулгын соёлын хүрээнд авч үзэх гол ойлголт нь цаг хугацаа болно. Энэ нь эртний үеийн мөнх оршихуйн төсөөллөөс уламжилсан байх талтай. “Цаг хугацааны мөнхийн шалтгаан, түр хугацааны солигдож буйг ялгах үүднээс өдөр тутмын баримжаанд зориулсан долоо хоног, цаг, хором гэх мэт

хуваадаг. Сонгодог эртний үед цаг хугацааг орчлон ертөнцийн амьдралтай холбож үздэг байсан учраас зарим үед тэнгэрийн эрхсийн хөдөлгөөнтэй адилтгадаг” (ШУА-ийн ФХ 2023, 1420). Оршуулах зан үйл нь талийгаачийг “түүхэн цаг хугацаанаас” гаргаж, хойд насны диваажин тамын цаг хугацаа руу шилжүүлж буй хэрэг юм.

Эртний монголчууд нийгэмжүүлэн-хүнийсгэх зарчмаар ертөнцийг төсөөлж байсан бөгөөд тэнгэрүүдийн тухай домгийн өгүүлэмжид зүг болон өнгөний бэлгэдлийн сацуу монголчуудын аж амьдрал, үйл ажиллагааны эрхэмлэлүүд тод илэрдэг (Ариунболд, Цогтсайхан 1997, 52). Тухайлбал, монголчууд оршуулгад цагаан өнгийг бэлгэдэж, цагаан чулуутай газар хөдөөлүүлдэг заншилтай. Дундад эртний монгол булшинд үхэгсдийн шарилыг бараг нэгэн ижил хэвшмэл байдлаар тавьж байсан ба хүүрийн толгойг ихэвчлэн хойд зүг чиглүүлэн оршуулж байсан нь тэдний гэрийн доторх суудал ба орон зайн хуваарилалтын дэг ёсыг тусгасан мэт байна (Эрдэнэбат 2018, 107).

Оршуулгын газар бол амьд ба үхэгсдийн ертөнцийн зааг дээрх ариун орон зай гэж үздэг. Энэхүү орон зайн зохион байгуулалт нь нутаг орон, тэнгэр, газар, орон гэрийн зайд бэлгэдэл, зан үйлийг болгоно. Монголчууд булах, чандарлах, занданшуулах, ил тавих гэх мэт хэлбэрийг нийтэд нь нутаглуулах, хөдөөлүүлэх гэж нэрлэдэг нь газар дэлхийдээ шингэж байдаг гэсэн төсөөллөөс үүссэн байж болох юм. “Байгаль шүтлэгийн домгийн элементүүдийг ургамал, газар, уул, амьтан, ус, тэнгэр гэх мэтээр ангилдаг (Соёлмаа 2024, 26). Тухайлбал, арц модыг монголчууд ариун хэмээн, оршуулгын үед ариусгах зан үйлд хэрэглэдэг”.

Олон соёлд бие махбод үхэвч “сүнс” эсвэл “энерги” үлдэнэ гэж үздэг итгэл үнэмшил нь оршуулгын хэлбэрийг сонгох шалтгаан болдог байна. Булш бол тухайн ард түмний орон сууцных нь хэлбэрийг тусгах бөгөөд булшийг нас барсан хүний сүнс нөгөө ертөнцөд суух гэр хэмээн үздэг монголчуудын ойлголт, төсөөлөл бүр эртнээс улбаатай (Эрдэнэбат 2018, 107). Дундад үеийн монголчуудын төсөөллөөр үхэгсдийн орон гэж уулын ээвэр, энгэр газар ажээ. Учир нь оршуулгын зан үйлийн булж оршуулах хэлбэр эрт үеэс дэлгэрч, өнөөг хүртэл уламжлан ирсэн бөгөөд оршуулгын үндсэн хэлбэр байсан. Оршуулгын газар нь ихэвчлэн газрын шинж байдлаар тодорхойлогдох хэдий ч нар ээсэн энгэр газар, уул, ариун дагшин, шүтлэгтэй газар байж болох бөгөөд “Их хориг” гэх мэтээр нууцлагдах явдал ч байжээ.

Түүхийн аль ч цаг үед оршуулгын соёл хувьсан өөрчлөгдөж, бусдын соёлын нөлөөг тусгах тохиолдол ч байжээ. Тухайлбал, хятанчуудын оршуулгын зан үйл уламжлалаа хадгалж байсан боловч бусад шашны болоод үзэл суртлын агуулгаар баяжуулсан нь Хятан улсын эхэн үеийн оршуулгын байгууламжуудаас тод харагдана (Одпүрэв 2022, 231-238). Мөн эртний монголчуудын хувьд булж оршуулах явдал түгээмэл байсан бол шарын шашин хүчтэй дэлгэрэхийн хамт нийтээр ил задгай оршуулахыг дэлгэрүүлсэн ба XVI-XVII зууны үеэс ноёд, дээд лам нарыг чандарлах, чандрыг бумбад хийж дээр нь суварга барин оршуулах, хүүрийг хатааж сүм бунхан барин хадгалах болсноор “Бунхант”, “Бумбат”, “Шарилт” гэдэг газар зүйн нэр гарсан байна (Жигмэддорж, Идэрмаа 2017, 121-129).

Монгол нутгаас илэрч олдоод байгаа эртний булшны оршуулгын газар сонгох ёс, оршуулгын зан үйлд дагалдуулсан зүйлс, чулуу, хөшөө босгох зэрэг нь эдүгээ ч

уламжлагдаж буйг судлаачид тэмдэглэжээ. Эртний хүмүүсийн оршуулгын зан үйлд 3500 жилийн тэртээгээс жирийн иргэдийн, хаад язгууртны оршуулгын зан үйл гэж гадаад болон дотоод хэлбэрийн ялгаа өөрчлөлт гарсан боловч, тэр нь дагалдуулан тавьсан эдийн соёлын их багын ялгаа, хойлоглосон малын тоо толгойн ялгаа гарч байсан болохоос ёс заншлын ялгаа гарч байгаагүй ажээ (Эрдэнэбаатар 2019). Энэ бүхнээс үзэхэд, оршуулгын зан үйл нь хүний бие махбод үхэвч сүнс мөнх гэдгийг оршин байхуйн хэлбэрийг нь өөрчлөх болон биологийн биеийг оюун санааны бие болгон хувиргах байдлаар илэрхийлдэг нийгэм-соёлын үзэгдэл юм.

Хэлэлцүүлэг

Дээрхээс үзэхэд, хүн төрөлхтний оюун санааны домгийн, шашны, шинжлэх ухааны, технологийн хөгжлийн үе шатаас хамаарч оршуулгын соёл өөрчлөгдсөөр байна. Философийн онтологийн үндсэн ойлголт болох орон зай, цаг хугацаа, бэлгэ тэмдэг, харилцан үйлчлэл, хөдөлгөөн, тусгал гэх мэт нь оршуулгын хүрээнд бэлгэдэлт утгаар хэрхэн уламжлагдаж буй нь оршуулгын соёлын цөм бүрдлийг илэрхийлдэг. Бие ба сүнсний дуализм (хоёрдмол үзэл) оршуулгын соёлын гол үндэс болдог. Оршуулгын соёлын архетип нь бие махбодыг оршуулж буй ч оюун санааны хувьд өөр орон зайд шилжүүлж буй үйлээр тодорхойлогдоно.

Соёлын онолын гол төлөөлөгч С.Гийрц “шашны бэлгэ тэмдгийг, ариун бэлгэ тэмдгээс ялгаж тайлбарласан, шашны бэлгэ тэмдэг бол шидэт домогтой холбогдсон бөгөөд зан үйлүүд нь хэтрүүлэлтэй, хэрхэн нэгтгэсэн мэдрэмж төрүүлэх вэ гэдэгт анхаарсан, сэтгэл зүйг нь дэмжсэн байдаг. Харин ариун бэлгэ тэмдэг нь гоо сайхан, ёс суртахууны космологи, онтологид холбогддог, хэм хэмжээлэг утга юм” (Geertz 1973, 126-127) хэмээсэн байна. Энэ үүднээс нас нөхцөгчийн оршуулга нь үлдэгсдийн хувьд айдас түгшүүрийг даван туулж, ертөнцийг “утга учиртай” хэмээн дахин итгэж үнэмших бололцоог олгох арга зам гэж болно.

Домог зүйн судалгаанд үлэмж их хувь нэмэр оруулсан шашин болон соёлын онтологийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг М.Элиаде (Mircea Eliade) оршуулгын зан үйлийг “салах ёс” гэж үзээгүй, харин үүнийг онтологийн шилжилт (ontological transition) буюу нэгэн оршихуйгаас нөгөөд шилжих ариун үйл явц гэж тайлбарлажээ. Тухайлбал, ...Бодит байдалд домгууд нь зөвхөн ертөнц, амьтад, ургамал хийгээд хүний гарал үүслийн тухай төдийгүй, мөн нэн чухал үйл явдлуудын тухай мэдээлсэн байдаг... ...домгууд нь сакраль утгаа хадгалсан үнэн домог бөгөөд үлгэрийн төрөлд хамааруулах зохиомол домог байхгүй гэдгээрээ онцлогтой. Өөрөөр хэлбэл, санаанаас зохиосон хууч яриа гэхээр домог байдаггүй (Галаарид 2022, 11) гэж үздэг. Иймээс оршуулга нь талийгаачийг нөгөө ертөнцөд шилжүүлдэг гэсэн үзэл домогт түгээмэл илэрдэг нь энэ талын судалгаанд зайлшгүй харгалзах зүйл мөн.

Дүгнэлт

Оршуулгын соёлын онтологи нь хүний оршихуй, үхэл, үхлийн дараах амьдрал, хойд төрлийн талаарх философийн суурь асуудлуудыг хөнддөг. Үхэл бол зөвхөн биологийн төгсгөл бус, харин хүний оршихуйн нэг хэлбэр юм. Үхэл байгаа учраас амьдрал утга учиртай, үнэ цэнтэй бөгөөд нас нөхцөгчийг хүндэтгэх хүнлэг ёсны

илэрхийлэл нь оршуулгын зан үйлээр илэрдэг. Оршуулгын зан үйл нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, сүнс, биеийн хамаарлын талаарх шашин шүтлэгийн хандлага, төсөөлөл, мөнх ба мөнх бус цаг хугацааны эргэлт, нөгөө ертөнцийн ахуйн тухай үзэлд суурилдаг байна. Үүнийг агуулсан оршуулгын соёл нь хүнийг биологийн хувьд төгссөн ч нийгмийн болон онтологийн хувьд оршсоор байгааг илэрхийлдэг хавсарга соёл судлалын ойлголт. Жишээ нь, дурсгалын хөшөө, тахил тайх ёс нь тухайн хүнийг огт байхгүй биш, харин өөр төлөв, орон зайд шилжсэн хэмээх утга санаа бүхий зан үйл бөгөөд үндэстэн, угсаатны шашин, соёлын онцлогийг тусгасан байдаг.

Оршуулгын соёлын субъект нь хүн, угсаатан, нийгмийн бүлэг бөгөөд байгаль ч субъектийн байр сууриар илрэх боломжтой. Жишээ нь, байгалийг хүнчилдэг домгийн сэтгэлгээний үүднээс, байгаль нь оршуулгын зан үйлд амьтай субъект байдлаар илэрдэг гэж судлаачид үзжээ. Харин оршуулгын соёлын объект нь оюун санааны ертөнц, сүнс, үхэшгүй мөнх, орон зайн шилжилт юм. Цаашид монголчуудын оршуулгын соёлын уламжлалыг соёлын философи, экологи, антропологи, шашин судлал зэрэг нийгэм хүмүүнлэгийн ухааны салбар дундын судалгаагаар тодруулах шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

- Ариунболд, Д., Цогтсайхан, Д. 1997. *Эртний монголчуудын нийгмийн тухай төсөөлөл*. ШУА-ийн ФСХ. Монголын философийн түүх I. Улаанбаатар.
- Дашжамц, Д. 1997. *Овог, аймаг, төр улс тогтнох үеийн зан суртахуун, ёс заншил*. ШУА-ийн ФСХ. Монголын философийн түүх I. Улаанбаатар.
- Галаарид, Б. 2022. “Монголын нууц товчоон дахь чинадын ухааны эрэлд.” *Монголын соёл, урлаг судлал* 42: 10-25.
- Гантөмөр, С., Дондог, Х. 2023. “Буддын шинжлэх ухааны товч.” *Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл*. Ред. Насанбат, Н. Улаанбаатар: Бит пресс.
- Дулам, С. 2025. *Монгол соёлын тайлбар толь бичиг*. Улаанбаатар: Нандир.
- Жигмэддорж, Э., Идэрмаа, Г. 2017. “Орчин үеийн монголчуудын оршуулгын ёсон дахь шашны зан үйлийн асуудалд.” *Философи, шашин судлал*. Vol. 19, 475: 121-129. <https://doi.org/10.22353/prs20171.16>
- Идэрмаа, Г. 2023. “Монголын төрөөс оршуулгын талаар баримталсан бодлого Нийслэл хотын жишээн дээр (1911-2021 он).”, Ph.D дисс. Монгол Улсын их сургууль.
- Одпүрэв, Г. 2022. “Хятан улсын оршуулгын зан үйл ба бунхны зураг.” *Монголын соёл, урлаг судлал* Vol. 42: 231-238.
- Отгонбаяр, Ж. 2012. “Хүний мөн чанарын тухай Макс Шелерийн үзэл.” *Философи, шашин судлал*. Vol. 13, 65 (371): 51-59. <https://doi.org/10.22353/prs20121.6>

Оюунгэрэл, Д. 2006. “Хүний амьдралын утга учрын талаарх экзистенциалист баримтлалын онцлог.” *Философи, шашин судлал* 263 (34): 184-191.

Соёлмаа, С. 2024. “Монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууны үндэс: байгаль шүтлэгийн домог.” *Философи, эрх зүйн судлал* 48 (39): 23-32.

Цэрэнханд, Б. 2018. *Шашны психологийн ба бусад төрлийн бэлгэдэлт мэдээг К.Г.Юнг философийн үүднээс шинжилсэн онцлог*. Ред. Гомбосүрэн, Ц. Улаанбаатар: Тод бичиг.

Эрдэнэбат, У. 2018. “Нүүдэлчдийн булшны байгууламжид тэдний уламжлалт гэр сууцны хэлбэр, оройн зайн хуваарилалт тусгагдсан нь.” *Монголчуудын хойлгын зан үйл. ЭШХ-ын материал*. Ред. Дэлгэржаргал, П. Улаанбаатар.

Эрдэнэбаатар, Д. 2019. *Ориуулгын зан үйлийн хувьсал өөрчлөлт*. <https://sergelen.org/post/f4b9cfdd>. 2026.01.26.

ШУА-ийн ФХ. 2023. *Философийн шинэ нэвтэрхий толь*. Ред. Лодой, Г., Даш-Ёндон, Б. Улаанбаатар: Соёмбо принт.

Гадаад хэлээр:

Mircea Eliade. 1956. *The Sacred and the profane nature of religion*. Translated from the French by Willard R. Trask. A Harvest Book Harcourt, Brace & World, Inc. New York.

Clifford, Geertz. 1973. *The Interpretation of Cultures*. New York.

Heywood, Paolo. 2023. “Ontological turn, the.” In *The Open Encyclopedia of Anthropology*. edited by Felix Stein. Facsimile of the first edition in *The Cambridge Encyclopedia of Anthropology*. <http://doi.org/10.29164/17ontology>